9

# УЛААНБААТАР
## ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
# ТОГТООЛ

1979 оны 1 дүгаар сарын 15-ны өдөр | Дугаар 8 | Улаанбаатар хот

БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН ТОВЧОО БАЙГУУЛАХ ТУХАЙ

ГЗ-ны 1990 оны 140-р тогтоолоор хүчингүй

БНМАУ-ын Улс Төлөвлөгөөний комисс хөдөлмөр цалин хөлсний улсын хороотой тохиролцсоны үндсэн дээр Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ НЬ:

1.Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны их барилгын хэлтэс /н.Жаргал/-д ДААЛГАХ НЬ:

а/БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1969 оны 229-р тогтоолыг удирдлага болгон Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны барилга захиалагчийн товчоог 1979 оны I-р сарын I-ээс эхлэн байгуулж аж ахуйн тооцоон дээр ажиллуулах.

б/БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1977 оны 355-р тогтоолын заалтын дагуу Улаанбаатар хотын барилга захиалагчийн нэгдсэн товчоо байгуулах асуудлыг БНМАУ-ын Улсын төлөвлөгөөний комисст 1979 оны I-р улиралд багтаан оруулж шийдвэрлүүлэх.

2.Хөдөлмөр Цалин Хөлсний Улсын Хорооны 1969 оны 149, 1976 оны 116-р тогтоолыг баримтлан Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны барилга захиалагчийн товчооны орон тоог II нэгжээр хавсралт ёсоор 6 сарын хугацаагаар түр мөрдөхөөр батласугай.

3.Улаанбаатар хотын барилга архитектурын газрын барилга захиалагчийн товчооны инженер техникийн ажилтны хэрэглэж байсан конторын эд хогшлыг Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны барилга захиалагчийн товчоонд балансаас балансад шилжүүлэхийг хотын архитектур, төлөвлөлтийн газар /н.Жадамбаа/-д даалгасугай.

УЛААНБААТАР ХОТЫН АДХ ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ДАРГА Д.МӨНХЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Ч.ЖАМБАЛ

Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргааны 1979 оны 8 -р тогтоолын хавсралт

УЛААНБААТАР ХОТЫН АДХ ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ БАРИЛГА ЗАХИАЛАГЧИЙН ТОВЧООНЫ ОРОН ТОО, ЦАЛИН

| Албан тушаалын нэр | орон тоо | сарын цалин | сарын фонд |
|---|---|---|---|
| 1.Дарга еренхий инженер | I | 850 | 850 |
| 2.Инженер | 7 | 700-750 | 5075 |
| 3.Ня-бо | I | 600 | 600 |
| 4.Архив бичиг хэрэг бичээч | I | 500 | 500 |
| 5.Техник нярав | I | 500 | 500 |
| Дүн | II | - | 7525 |

УЛААНБААТАР ХОТЫН АДХ ЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ ИХ БАРИЛГЫН ХЭЛТЭС